

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 03 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – БНХАУ, ОХУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2023 он)

7.0 хувь

Валютын нөөц

(2024 оны 3 дугаар сар)

5,250 сая \$

Инфляц

(2024 оны 3 дугаар сар)

7.0 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 3 дугаар сар)

1.6 их наяд ₮

Экспорт

(2024 оны 3 дугаар сар)

3,659 сая \$

Импорт

(2024 оны 3 дугаар сар)

2,414 сая \$

ГШХО

(2023 он)

3.1 тэрбум \$

Зээлийн хүү

(2023 оны 3 дугаар сар)

17.0 хувь

Ажилчдын тоо

(2023 оны 4 дүгээр улирал)

1.2 сая

*Ув улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 58 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)

16.4 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2023 оны эцэс)

96.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)


14.1 хувь



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний улиралд 13.6 хувиар өсөөд байна. Нүүрс, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг дэмжсэн хэвээр байгаа бол хөнгөн үйлдвэрлэл буурч, боловсруулах салбарын өсөлтийг хязгаарлав.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)



БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(өсөлтийн хувь)




УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

(голлох бүтээгдэхүүнээр)



ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны нэгдүгээр улиралд 7.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар өслөө.
- Нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 14.5 хувиар нэмэгдээд байна.
- Ус ундаа, цагаан архи, тамхи, шохой, металл бэлдэц зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбар 9.9 хувиар өслөө.

- Аж үйлдвэрийн салбарын бодит үйлдвэрлэл 2024 оны нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өсөөд байна.
- Үүний 6.6 нэгж хувийг уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт бүрдүүлж байна.
- Мөн боловсруулах, цахилгаан, усан хангамж зэрэг бусад аж үйлдвэрийн салбаруудын үйлдвэрлэл нэмэгдлээ.

- Нүүрс олборлолт 2024 оны эхний улиралд 22 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс 63 хувиар нэмэгдээд байна.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны эхний улиралтай ойролцоо түвшинд байгаа бол алт олборлолт 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Харин газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшинг даваагүй хэвээр байна.


- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 1.2 хувь, цар тахлын өмнөх үеэс 63 хувиар тус тус өслөө. Үнийн индексийг салбараар харвал:
- Хүнсний бүтээгдэхүүн 14.9 хувиар,
- Ундаа, согууруулах ундаа 7.6 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 7.8 хувиар тус тус өссөн бол
- Уул уурхай, олборлолтын үйлдвэрлэл 0.2 хувиар,
- Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 0.4 хувиар тус тус буурлаа.



Гадаад, дотоод эрэлт эерэг төлөвтэй байж, эдийн засаг өсөлтөө хадгаллаа.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



- Эрэлтээс тооцсон ДНБ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 6.1 нэгж хувийн, цэвэр экспорт 5.2 нэгж хувийн тус тус эерэг нөлөө, хөрөнгийн хуримтлал -4.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүллээ.

ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



- Эцсийн хэрэглээ 2023 онд 25.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өсөв.
- Эцсийн хэрэглээний өсөлтийн 5.7 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 1.6 нэгж хувийг төрийн хэрэглээ бүрдүүлж байна.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 7.0 хувиар өслөө.
- Үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлтөд орон сууцны бус барилга байгууламж 6.4 нэгж хувийн, машин тоног төхөөрөмж 2.7 нэгж хувийн, орон сууцны барилга 0.6 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг тус тус үзүүлсэн бол том малын хорогдол 2.4 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүллээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт 2023 онд импортоос 2 дахин хурдтай нэмэгдлээ.
- Бараа, үйлчилгээний цэвэр экспорт -7.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 16.6 хувиар буурав.




2024 оны эхний 3 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 1,245 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 32 хувиар буурлаа.

ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2024 оны 3 дугаар сарын байдлаар экспорт 3,659 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурлаа.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 60 хувийг бүрдүүлж байна.

- Нүүрсний экспортын орлого 2,213 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурлаа.
- Зэсийн баямалын экспортын орлого 638 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өслөө.
- Алтын экспортын орлого 214 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 90 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 28 хувиар өслөө.

- 2024 оны 3 дугаар сарын байдлаар импорт 2,414 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар өссөн байна.
- Нийт импортын 21 хувийг нефт, 17 хувийг тоног төхөөрөмж, 10 хувийг автомашин эзэлж байна.


- Нефтийн бүтээгдэхүүний импорт 504 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн 34.4 хувиар өслөө.
- Тоног төхөөрөмжийн импорт 421 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 31.1 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 252 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 87.3 хувиар өслөө.



2024 оны эхний 3 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 оны 3 дугаар сард 6.8 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 15 хувиар өслөө.
- Гашуунсухайт боомтоор 3.5 сая тонн, Шивээхүрэн боомтоор 2.2 сая тонн, Ханги боомтоор 0.7 сая тонн, бусад боомтуудаар 0.4 сая тонн нүүрс экспортолсон байна.

- Зэсийн баяжмалын экспорт 2024 оны 2 дугаар сард 114 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар буурлаа.
- Гашуунсухайт боомтоор 61 мянган тонн, Зам-үүд боомтоор 53 мянган тонн зэсийн баяжмал экспортолсон байна.

- Төмрийн хүдрийн экспорт 2024 оны 3 дугаар сард 682 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 44 хувиар өслөө.
- Зам-үүд боомтоор 621 мянган тонн, Бургастай боомтоор 53 мянган тонн, бусад боомтуудаар 8 мянган тонн төмрийн хүдэр экспортолсон байна.


- Газрын тосны экспорт 2024 оны 2 дугаар сард 346 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 312 мянган баррель, Замын-үүд боомтоор 34 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.



2024 оны эхний 3 сард сарын ноос, ноолуураас бусад голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

БОЛОВСРУУЛСАН АРЬС ШИР


(мянган дм квадрат)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС

(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 оны эхний 3 сард 16,439 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 33 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багасаж 4,357 мянган тоннд хүрлээ.

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 3 сард 9,089 мянган дм квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 33 хувиар буурлаа.


- Ноолуурын экспорт 2024 оны эхний 3 сард 198 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 64 хувиар өслөө.

- Ноосны экспорт 2024 оны эхний 3 сард 30 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 60 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА


НҮҮРС (\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 3 сарын дундаж үнэ 289 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурсан байна.


ЗЭС (\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 3 сарын дундаж 8,678 ам.доллар болж, өмнөх оны мөн 8 хувиар буурсан байна.


ТӨМРИЙН БАЯЖМАЛ (\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 3 сарын дундаж үнэ 110 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 1 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС (\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг


Бrent газрын тосны 2024 оны эхний 3 сарын дундаж үнэ 84 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 7 хувиар өслөө.



2024 оны эхний 3 сарын байдлаар УУББ-ээр 9 төрлийн, нийт 22 сая тонн нүүрс болон 1,121 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА


(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ


(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН АРИЛЖАА


(мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 3 дугаар сарын байдлаар нийт 22 сая тонн нүүрс арилжиж, 3.0 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 3 дугаар сарын байдлаар 2024 онд 7.3 сая тонн нүүрс арилжиж, 898 сая ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 2 дугаар сард 2.4 сая тонн нүүрс борлуулсан бол 3 дугаар сард 1.3 сая тонн нүүрс борлууллаа.

- Нүүрсний 3 дугаар сард дуудах дундаж үнэ 142 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 153 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 3 дугаар сард хэлцлийн доод үнэ 54 ам.доллар, дээд үнэ 194 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 153 ам.доллар байна.

- 2023 оны 9 дүгээр сараас хойш 2023 онд нийт 677.5 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 196 тэрбум төгрөг буюу 57 сая ам.долларын борлууллаа.
- 2024 оны эхний гурван сарын байдлаар 444 мянган тонн төмрийг арилжаалж, 34 сая ам.долларын орлого олжээ.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 3 дугаар сарын дуудах дундаж үнэ 70 ам.доллар хүрч буурсан ба арилжааны үед үнэ өөрчлөгдөөгүй.
- Төмрийн төрлөөс хамааран 3 дугаар сард хэлцлийн доод үнэ 65 ам.доллар, дээд үнэ 90 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 70 ам.доллар байна.

4.2 УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА - Компаниар 2024.03 сар



2024 ОНЫ ЭХНИЙ 3 САРЫН НИЙТ АРИЛЖАА

юанаарх үнийг ам.доллар луу шилжүүлэв.

НИЙТ НҮҮРС

5,222 68
мян. тонн арилжаа
\$705,049

НҮҮРС

"Эрдэнэс Тавантолгой" ХК

4,314 13
мян. тонн арилжаа
\$546,700

"Энержи Ресурс" ХХК

896 54
мян. тонн арилжаа
\$156,393

"Хангад Эксплорэйшн" ХХК

13 1
мян. тонн арилжаа
\$1,956

НИЙТ ТӨМӨР

359 59
мян. тонн арилжаа
\$27,969

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

"Монголросцветмет" ТӨҮГ

99 18
мян. тонн арилжаа
\$9,819

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК

72 12
мян. тонн арилжаа
\$5,383

ТӨМРИЙН ХҮДЭР

"Монголросцветмет" ТӨҮГ

102 17
мян. тонн арилжаа
\$7,788

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК

85 12
мян. тонн арилжаа
\$4,979

Арилжааны мэдээлэл


№	Огноо	Худалдагч	Бүтээгдэхүүний төрөл	Хэлцлийн үнэ (\$)	Үнийн өсөлт
426	2024-03-29	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$66.0	1.5%
425	2024-03-28	"Эрдэнэс Тавантолгой" ХК	1/3 коксжих нүүрс	\$105.1	12.3%
424	2024-03-28	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$65.0	0.0%
423	2024-03-27	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$65.5	0.8%
422	2024-03-26	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$65.5	0.8%
421	2024-03-25	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$173.0	0.0%
420	2024-03-22	"Эрдэнэс Тавантолгой" ХК	1/3 коксжих нүүрс	\$111.1	18.7%
419	2024-03-22	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$173.6	0.0%
418	2024-03-21	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$70.0	0.0%
417	2024-03-21	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$173.6	0.0%
416	2024-03-20	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$70.0	0.0%
415	2024-03-19	"Эрдэнэс Тавантолгой" ХК	Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс	\$160.2	11.5%
414	2024-03-18	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$173.7	0.0%
413	2024-03-15	"Эрдэнэс Тавантолгой" ХК	1/3 коксжих нүүрс	\$110.1	23.6%
412	2024-03-15	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$175.2	0.8%
411	2024-03-14	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$71.0	1.4%
410	2024-03-14	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$178.0	2.4%
409	2024-03-13	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$70.0	0.0%
408	2024-03-13	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$181.2	4.0%
407	2024-03-12	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$70.0	0.0%
406	2024-03-12	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан коксжих нүүрс	\$182.4	4.8%
405	2024-03-11	"Энержи Ресурс" ХХК	Баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрс	\$76.4	10.0%
404	2024-03-11	"Монголросцветмет" ТӨҮГ	Төмрийн хүдэр FE-52%	\$71.0	1.4%




2024 ОНЫ ЭХНИЙ 3 САРЫН
НИЙТ АРИЛЖАА

юанаарх үнийг ам.доллар луу шилжүүлэв.


Нүүрс: хэлцлийн жигнэсэн дундаж үнэ (\$)




Нүүрс: биет хэмжээ (мян. тонн)



Төмөр: хэлцлийн жигнэсэн дундаж үнэ (\$)




Төмөр: биет хэмжээ (мян. тонн)






Төлбөрийн тэнцэл 2024 оны 2 дугаар сард ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2024 оны 3 дугаар сарын эцэст өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум ам.доллар буюу 52.7 хувиар өсөж, төгрөгийн ам.доллартой харьцах ханш чангарсан хэвээр байна.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)




- Төлбөрийн тэнцэл 2024 оны 2 дугаар сард 39 сая ам.долларын ашигтай гарч, ашиг өмнөх оны мөн үеэс 28 сая ам.доллараар буурлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 70 сая ам.доллараар буурсан бол импорт 465 сая ам.доллараар нэмэгдсэнээр урсгал дансны ашиг өмнөх оны мөн үеэс буурлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны 2 дугаар сард 534 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 320 сая ам.доллараар өссөн байна.

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)




- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 5,250 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум ам.доллар буюу 52.7 хувиар өслөө.
- Энэ нь сүүлийн 12 сарын дунджаар тооцсон барааны импортын 6.5 сарын хэрэгцээг хангах түвшин.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



- 2024 оны 3 дугаар сард төгрөгийн ам.доллартой харьцах ханш өдөрт дунджаар 0.3 төгрөгөөр чангарлаа.
- 2024 оны 3 дугаар сарын эцэст төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,376 болж, оны эхнээс 35 төгрөгөөр буюу 1.0 хувиар чангарлаа.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)




- Төв банк 2024 оны 3 дугаар сард нийт 348 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 15 сая ам.доллар буюу 7 хувиар их, 2022 оны мөн үеэс 249 сая ам.доллараар буюу 42 хувиар бага дүн байв.

*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн



Инфляц 2024 оны 3 дугаар сард 7.0 хувь гарч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдсан хэвээр байна. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.9 хувиар өсжээ.


ЖИЛИЙН ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.4 нэгж хувь (34.1%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 4.6 нэгж хувь буюу 65.9 хувийг эзэлж байна.


САРЫН ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- 2024 оны 3 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.9 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөхөд хүнсний бүлэг 58.4 хувиар нөлөөлжээ.
- Сарын инфляцад мах, махан бүтээгдэхүүн 28%, сүү 3%, талх, гурил, будаа 14%-ийг тус тус бүрдүүлж байна.


СУУРЬ ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 3 дугаар сард суурь инфляц 6.1 хувь гарч, нийт инфляцын 4.1 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 7 сар дарааллан буурч байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 3 дугаар сард жилийн инфляцын 24 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар өслөө.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 3 дугаар сарын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд уул уурхайн салбараас орж ирэх АМНАТ-ийн орлого болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өссөн нь голлон нөлөөллөө.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД


(зарлагын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

■ Нэгдсэн төсөв 2024 оны 3 дугаар сард 1.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 969.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

■ Орлого 2024 оны 3 дугаар сард 7,7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 2.6 их наяд төгрөг буюу 51.3 хувиар нэмэгдсэн байна.

■ Дээрх өсөлтөд орлогын албан татвар 1.1 их наяд төгрөг, АМНАТ 322 тэрбум төгрөг, НӨАТ 304 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.

■ Зарлага 2024 оны 3 дугаар сард 5,7 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 1.6 их наяд төгрөг буюу 37.6 хувиар нэмэгдсэн байна.

■ 2024 онд төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, алслагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.


■ Засгийн газрын өр 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 43.7 хувьд хүрээд байна.

■ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн хурд өмнөх сараас 3.4 нэгж хувиар буурлаа. Өмнөх сартай харьцуулахад гадаад валютын харилцах, хадгаламж буурч, төгрөгийн харилцах, хадгаламж нэмэгдсэн байна. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өмнөх сараас нэмэгдлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 3 дугаар эцэст 37.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 20.9 хувиар өссөн байна. Төгрөгийн харилцах, хадгаламж нийт өсөлтийн 25.8 нэгж хувийг, гадаад валютын харилцах, хадгаламж нийт өсөлтийн -5.1 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 22.6 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 18.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.6 хувиар, өмнөх сараас 3.1 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар, өмнөх сараас 7.8 хувиар тус тус буурлаа.

- Банкнүүдын зээлийн үлдэгдэл 2024 оны 3 дугаар сарын эцэст 28.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 7.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар буурсан байна.

- Банкнүүдын зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 3 дугаар сард 17.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсөв.
- Банкнүүдын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 3 дугаар сард 11.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар өслөө.




Эдийн засаг сүүлийн 6 улирал дараалан эерэг өсөлттэй байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт цар тахлын өмнөх түвшнээс бага хэвээр байна. Мөн сүүлийн 5 улирал дараалан ажиллах хүч буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэлсэн байна.

АЖИЛЧДЫН ТОО, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн, хувь)




АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)



ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



- Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 38.6 мянгаар нэмэгдэж, 1,197 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 8.4 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- Хүйсээр харвал, 2023 оны 4 дүгээр улиралд эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 21.2 мянгаар нэмэгдсэн бол эрэгтэй ажилчид өмнөх оны мөн үеэс 17.4 мянгаар өссөн байна.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 57.6 хувь болж буурсан ба цар тахлын өмнөх үеэс 2.5 хувиар доогуур байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 15.8 мянган хүнээр буурч, 48.8 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурч, 3.9 хувьд хүрлээ.

- Ажилчдын тоо 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.2 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 мянган хүнээр нэмэгдсэн ч өсөлтийн хурд бага байна.
- Ажилчдын тооны өсөлтөд, худалдаа, барилга, боловсруулах, тээвэр, үйлчилгээ ба бусад, уул уурхай, ус, цахилгааны салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид сөргөөр нөлөөллөө.

- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, 2,235 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.3 дахин өндөр байна.



БНХАУ-ын эдийн засаг 2024 оны эхний улиралд 5.3 хувиар өслөө. 2024 оны 3 дугаар сард гадаад худалдаа, аж үйлдвэрлэл болон жижиглэн худалдааны өсөлтийн хурд саарлаа. Гэсэн хэдий ч аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 3 дугаар сард босго утга 50-ийг давлаа.




- Аж үйлдвэр, үйлчилгээний салбарын идэвхжилийн нөлөөгөөр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны эхний улиралд 5.3 хувьд хүрч нэмэгдлээ.
- Аж үйлдвэрлэл нийт эдийн засгийн өсөлтийн 37.3 хувь буюу 2 орчим нэгж хувийг бүрдүүлээ.



- Экспорт 2024 оны 3 дугаар сард 7.5 хувиар агшсан ч эхний улиралд 1.5 хувиар өсөж, өмнөх улирлын 1.2 хувийн агшилтаас сэргэлээ.
- Экспорт огцом буурахад өнгөрсөн оны мөн үед экспортын өсөлт өндөр байсан суурь үеийн нөлөө өндөр байв.
- Импорт 2024 оны 3 дугаар сард 1.9 хувиар агшиж, эхний 3 сарын өсөлт 1.5 хувьд хүрлээ.



- 2024 оны 3 дугаар сард аж үйлдвэрийн гарцын өсөлт 6.1 хувь, жижиглэн худалдааны өсөлт 4.7 хувь болж тус тус буурлаа.



- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 3 дугаар сард 50.8 болж, өмнөх сараас 1.7 нэгжээр өсөж, өнгөрсөн 9 дүгээр сараас хойш анх удаа босго утга 50-аас дээш гарав.
- Аж үйлдвэрийн бус салбарын PMI индекс 50-аас дээш хэвээр байна.


Тус индекс нь богино хугацааны идэвхжлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ОХУ-ын ДНБ 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өссөн бол 2024 оны 1 дүгээр улиралд 4.1 орчим хувиар өснө гэсэн таамаглалтай байна. Өсөлтийг төсвийн зарлагын тэлэлт, аж үйлдвэрийн өргөжилт, цэрэг армийн зардал дэмжсэн байна.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны 4 дүгээр улиралд 4.9 хувиар өссөн байна.
- Засгийн газрын хэрэглээний зардал 2023 оны 4 дүгээр улиралд 6.0 хувиар өссөн байна.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг 2022 оны 1 дүгээр улирлаас хойш хамгийн өндөр өсөлт хүрээд байна.

ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ

(тэрбум ам.доллар)




Эх сурвалж: ОХУ-ын Төв банк

- Экспорт 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеийнхээс 6.9 хувиар, 2022 оны 1 дүгээр улирлын дүнгээс 36.7 хувиар тус тус буурсан байна.
- Импорт 2024 оны 1 дүгээр улиралд өнгөрсөн оны мөн үеэс 10.3 хувиар буурсан байна.
- Экспортын бууралтад тус улсын газрын тос, байгалийн хий, газрын тосны бүтээгдэхүүний үнийн бууралт, биет хэмжээний бууралт гол нөлөө үзүүлсэн байна.

ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Инфляцын түвшин 2024 оны 3 дугаар сард нэг жилийн дээд түвшин 7.7 хувийг хадгалсан хэвээр байна.
- Үнийн өсөлтөд үйлчилгээний үнэ (8.3 хувь), хүнсний бүтээгдэхүүний үнэ (8.1 хувь), хүнсний бус барааны үнэ (6.7 хувь) голчлон нөлөөлсөн байна.
- Инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сараас хойш аажмаар өсөж, Төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

(нэгж)



Эх сурвалж: Блүүмберг

- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 3 дугаар сард 55.7 болж, сүүлийн 7 жилийн хугацаанд хамгийн өндөр тэлсэн байна.
- Бодит үйлдвэрлэлийн өсөлт 2024 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өссөн нь сүүлийн 2 жилийн хугацааны хамгийн өндөр үзүүлэлт болсон байна.
- Шинэ захиалгын хэмжээ огцом нэмэгдсэн нь ажил эрхлэлтийг дэмжиж, бараа материалын худалдан авалтыг нэмэгдүүлсэн нь салбарын өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ